

БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Гурванбулаг сумын Засаг даргын тамгын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: БУА-2025/120/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:

www.audit.mn

Булган аймаг

2024 он

Дарга,

тэргүүлэх аудитор: Б.Эрдэнэ

Утас: 70342580

Цахим хаяг:

erdeneb@audit.gov.mn

Аудитын менежер: Ж.Энхцоодол

Утас: 70342716

Цахим хаяг:

enkhtsoodolj@audit.gov.mn

Аудитор: Д.Даариймаа

Утас: 70342495

Цахим хаяг:

daariimaado@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**БУЛГАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Анхдагчдын өргөн чөлөө 1-120,
Жаргалант, 5-р баг, Булган сум, Булган аймаг,
63082, Утас/Факс: 7034-2580
Цахим шуудан: bulgan@audit.gov.mn

2025.02.22 № 117

танай _____ ны № _____ т

Г УРВАНБУЛАГ СУМЫН ЗАСАГ
ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА
Б.ЭРДЭНЭТУЯА ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Гурванбулаг сумын ЗДТГ-ын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Гурванбулаг сумын ЗДТГ-ын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна.

Тайлант онд үндсэн хөрөнгийн дансанд төсвийн хөрөнгөөр 29.9, үнэ төлбөргүй 609.4 нийт 639.4 сая төгрөгөөр хөрөнгийн орлогын хөдөлгөөн хийгдсэн байна

Аудитын гол асуудал

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход

632502173

хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

Гурванбулаг сумын ЗДТГ нь өмнөх онтой хариуцуулахад цалингийн зардал 235.6 сая төгрөгөөр өссөн нь төрийн албан хаагчийн цалингийн шатлал нэмэгдсэнээс шалтгаалж байна.

Бусад асуудлын хэсэг

Гурванбулаг сумын ЗДТГ-ын 2024 оны хэрэгжүүлэх хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтэд тусгагдсан 13 зорилт 146 арга хэмжээний хэрэгжилт 84.9 хувиар дүгнэгдэж хөтөлбөр арга хэмжээнд зориулан 1,081.6 сая төгрөгийг төсөв батлагдан гүйцэтгэлээр 95.6 хувийг зарцуулсан байна.

Гурванбулаг сумын ЗДТГ-ын 2024 оны санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй, аудитад ажил гүйлгээг түүврийн аргыг ашиглан гүйцэтгэсэн болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН
АЛБАН ТУШААЛЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ  Ж.ЭНХЦООДОЛ



Хоёр. Санхүүгийн ба төсвийн гүйцэтгэлийн тайлангийн гол үзүүлэлт

| Үзүүлэлт | 2023.12.31 | 2024.12.31 |
|---|-------------------------|-------------------------|
| Санхүүгийн байдлын тайлан | | |
| Эргэлтийн хөрөнгийн дүн | 63,239,721.04 | 81,691,721.04 |
| Эргэлтийн бус хөрөнгийн дүн | 2,209,829,369.04 | 2,672,284,077.18 |
| Нийт хөрөнгийн дүн | 2,273,069,090.08 | 2,753,975,798.22 |
| Нийт өр төлбөрийн дүн | 0 | 0 |
| Цэвэр хөрөнгө/өмчийн дүн | 2,273,069,090.08 | 2,753,975,798.22 |
| Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн | 2,273,069,090.08 | 2,753,975,798.22 |
| Санхүүгийн үр дүнгийн тайлан | | |
| Үйл ажиллагааны орлогын дүн | 1,059,755,868.00 | 1,789,773,130.00 |
| Үйл ажиллагааны зардлын дүн | 1,141,048,977.36 | 1,302,448,421.86 |
| Үйл ажиллагааны үр дүн | (81,293,109.36) | 487,324,708.14 |
| Үйл ажиллагааны бус үр дүн | 8,437,670.57 | 6,418,000.00 |
| Үйл ажиллагааны нийт үр дүн | (89,730,779.93) | 480,906,708.14 |
| Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан | | |
| Дахин илэрхийлсэн үлдэгдэл | | 2,273,069,090.08 |
| Тайлант оны үр дүн | | 480,906,708.14 |
| Эцсийн үлдэгдэл | | 2,753,975,798.22 |
| Мөнгөн гүйлгээний тайлан | | |
| Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн | 991,744,988.00 | 1,163,827,650.00 |
| Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн | 991,744,988.00 | 1,133,830,820.00 |
| Үйл ажиллагааны ЦМГ | | 29,996,830.00 |
| Хөрөнгө оруулалтын ЦМГ | | -29,996,830.00 |
| Санхүүгийн ажиллагааны ЦМГ | | -29,996,830.00 |
| Нийт цэвэр мөнгөн гүйлгээ | | 29,996,830.00 |
| Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | 0 |
| Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | | 0 |
| Төсвийн гүйцэтгэлийн тайлан | | |
| Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн | 1,280,164,309.71 | 1,082,791,279.17 |
| Урсгал зардал | 1,280,164,309.71 | 1,052,794,449.17 |
| Хөрөнгийн зардал | - | 29,996,830.00 |
| Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр | - | 1,093,018,900.00 |
| Улсын төсвөөс санхүүжих | - | 0 |
| Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас | - | 1,093,018,900.00 |

Гурав. Байгууллага, түүний үйл ажиллагаа

Тайлант онд тус байгууллага Монгол Улсын хууль, Засгийн газрын бодлого, шийдвэрийг хэрэгжүүлэх, эрүүл дадал хэвшилтэй, эрдэм боловсролтой, тав тухтай амьдрах нөхцөл бүрдсэн, Хүний төлөө-Хөгжлийг дээдэлсэн зөв бодлого барьж ажиллан, тогтвортой эдийн засгийг бий болгох зорилт дэвшүүлэн ажилласан байна. **Дөрөв. Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлууд**

Гурванбулаг сумын Засаг даргын тамгын газрын 2024 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Гурванбулаг сумын Засаг даргын Тамгын газрын 2024 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 480,906.7 мянган төгрөгөөр буюу 21.0 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|----------------|----------------|-----------------|----------|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | - | - | - |
| Авлага | - | - | - |

| | | | |
|--|--------------------|--------------------|------------------|
| Бараа материал | 63,239.7 | 81,691.7 | 18,452.0 |
| Үндсэн хөрөнгө | 2,209,829.4 | 2,672,284.1 | 462,454.7 |
| Нийт хөрөнгө | 2,273,069.1 | 2,753,975.8 | 480,906.7 |
| Өр төлбөр | - | - | - |
| Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ | 2,273,069.1 | 2,753,975.8 | 480,906.7 |
| Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн | 2,273,069.1 | 2,753,975.8 | 480,906.7 |

Бараа материалын дансны үлдэгдэл 81,691.7 мянган төгрөг болж 18,452.0 мянган төгрөгөөр өссөн нь худалдан авсан материалаас бичиг хэргийн материал, аж ахуйн материал, сэлбэг хэрэгслийн материалыг зарцуулаагүй үлдэгдэлтэй холбоотой байна.

Үндсэн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл 2,672,284.1 мянган төгрөг болж, өмнөх оноос 462,454.7 мянган төгрөгөөр өссөн нь машин тоног төхөөрөмж, тавилга эд хогшил 29,996.8 мянган төгрөгөөр худалдан авч, орон нутгийн хөгжлийн сангаас 611,855.5 мянган төгрөгийн хөрөнгийг сумын Засаг даргын захирамжаар шилжүүлэн авч бүртгэлд тусгаж, тайлагнаснаас нөлөөлсөн байна.

Тав. Аудитын гол асуудал Төсвийн төлөвлөлт

Гурванбулаг сумын Засаг даргын тамгын газар нь 2024 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр болон нийт зарлагыг 895,318.1 мянган төгрөгөөр тооцон төсөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлснийг 27,216.8 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн 922,534.9 мянган төгрөгөөр өсгөн баталжээ.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 9 арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,093,018.9 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс олгож, гүйцэтгэлээр 1,082,791.3 мянган төгрөг буюу төсвийн 99.1 хувийг зарцуулж, 10,227.6 мянган төгрөгийн зарцуулаагүй үлдэгдлийг буцаан төвлөрүүлсэн байна.

Хүснэгт № 2 Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

| Д/д | Хөтөлбөр, арга хэмжээ | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | зөрүү | хувь |
|--------------|--|--------------------|--------------------|-----------------|-------------|
| 70106 | ОН-ын гүйцэтгэх засаглалын удирдлага | 1,093,018.9 | 1,082,791.3 | 10,227.6 | 99.1 |
| 80101 | Үндсэн үйл ажиллагааны зардал | 785,105.1 | 780,359.1 | 4,746.0 | 99.4 |
| 80106 | Баг, хорооны ҮАЗардал | 190,574.5 | 187,414.7 | 3,159.8 | 98.3 |
| 80205 | Мэдээлэл, сурталчилгааны зардал | 1,000.0 | 450.0 | 550.0 | 45.0 |
| 80802 | Ажил олгогчоос олгох тэтгэмж, | 49,453.1 | 47,703.1 | 1,750.0 | 96.5 |
| 81102 | Орон нутгийн нөөц хөрөнгө | 40,000.0 | 39,978.2 | 21.8 | 99.9 |
| 81701 | Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх зардал | 3,386.2 | 3,386.2 | - | 100.0 |
| 82212 | Хур хог хаягдал, орчны бохирдлын зардал | 13,500.0 | 13,500.0 | - | 100.0 |
| 82801 | Улсын их баяр наадмын зардал | 5,000.0 | 5,000.0 | - | 100.0 |
| 83115 | Нийгмийн бүлэгт чиглэсэн хөтөлбөр | 5,000.0 | 5,000.0 | - | 100.0 |

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

Зургаа. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх,

нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд 171 мэдээлэл мэдээлэхээс 2 мэдээлэл хугацаа болоогүй, бусад мэдээллийг хугацаанд нь бүрэн мэдээлсэн байна. Шилэн дансны тухай хуулийг бүрэн хэрэгжүүлэн ажиллаж, хугацаа хоцроосон буюу дутуу мэдээлэл байхгүй байна.

Долоо. Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй

Найм. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 78,675.2 мянган төгрөгийн зөрчил¹ илэрснээс 73,619.2 мянган төгрөгийн 2 зөвлөмж, 270.5 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт, 4,785.5 мянган төгрөгийн 2 албан шаардлагыг өгсөн.

8.1 Төлбөрийн акт

1.Тайлант онд шатахууны зардлаас 270.5 мянган төгрөгийн анхан шатны баримтгүй зарцуулсан байна.

8.2 Албан шаардлага

1. Тайлант онд Засаг даргын нөөц хөрөнгөнөөс урд бүсийн уулзалтад 4,475.3, мянган төгрөгийг зориулалт бус зарцуулсан байна.

2. Тайлант онд ажил олгогчоос 310.2 мянган төгрөгийг цалингийн зардалд бүлэг хооронд шилжүүлэн зарцуулсан байна.

8.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Үндсэн хөрөнгийн данстай холбоотой асуудал

Илрүүлэлт: Байгууллагын хөрөнгийг тооллогыг хийсэн боловч нягтлан бодогч тооцоо бодсон актаар баталгаажуулаагүй байна.

Өгсөн зөвлөмж:

Хөрөнгийн тооллогыг хагас бүтэн жилээр хийж гүйцэтгэхдээ нягтлан бодогч тооцоо бодсон актыг үйлдэж хэвших.

2. Зардлын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт: Үндсэн хөрөнгийн Барилга байгууламжийн дансанд бүртгэсэн 12 нэр төрлийн 54,769.5 0, тавилга эд хогшлын дансанд бүртгэлтэй 74 нэр төрлийн

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

18,849.6 мянган төгрөгийн элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн хөрөнгүүдийг дахин үнэлээгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Баланст байгаа үлдэх өртөггүй хөрөнгийг акталж, устгах дахин үнэлэх ажлыг зохион байгуулах.

Дээрх зөвлөмж, төлбөрийн акт, албан шаардлагын биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2025 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|--|-------------|----------|---------------|-------|-----------------|---------|---------|----------|--------------------------------------|---------------------|---|-----|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Үндсэн хөрөнгийн Барилга байгууламжийн дансанд бүртгэсэн 12 нэр төрлийн 54,769.5 0, тавилга эд хогшлын дансанд бүртгэлтэй 74 нэр төрлийн 18,849.6 мянган төгрөгийн элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн хөрөнгүүдийг дахин үнэлээгүй байна. | 1 | 73,619.2 | | | | | 1 | 73,619.2 | | | | |
| Байгууллагын хөрөнгийг тооллогыг хийсэн боловч нягтлан бодогч тооцоо бодсон актаар баталгаажуулаагүй байна. | 1 | - | | | | | 1 | - | | | | |
| Тайлант онд шатахууны зардлаас 270.5 мянган төгрөгийн анхан шатны баримтгүй зарцуулсан байна. | 1 | 270.5 | 1 | 270.5 | | | | | | | | |
| Тайлант онд Засаг даргын нөөц хөрөнгөнөөс урд бүсийн уулзалтад 4,475.3, мянган төгрөгийг зориулалт бус зарцуулсан байна. | 1 | 4,475.3 | | | 1 | 4,475.3 | | | | | | |
| Тайлант онд ажил олгогчоос 310.2 мянган төгрөгийг цалингийн зардалд бүлэг хооронд шилжүүлэн зарцуулсан байна. | 1 | 310.2 | | | 1 | 310.2 | | | | | | |
| Дүн | 5 | 78,675.2 | 1 | 270.5 | 2 | 4,785.5 | 2 | 73,619.2 | | 0 | 0 | 0 |